# 19.17. Арга хэмжээний мэдээлэл импортлох

Эрдэм шинжилгээний арга хэмжээний мэдээллийг эксел файл дээр бэлдэж татах боломжтой. Импортлох эксел файлын загвар нь системийн **Дата импорт ->Арга хэмжээ-> Загвар татах -> ResearchEventImportTemplate.xlsx** гэсэн нэртэй файл байна.




## Өмнөх нөхцөл

- Сургалтын байгууллага идэвхтэй төлөвтэй байна.
- Салбар, бүрэлдэхүүн сургууль үүсссэн байх, төлөв нь идэвхтэй байх.
- Сургалтын нэгж үүссэн байх, төлөв нь идэвхтэй байх.

## Зөвлөмж

- Тоо төрлийн талбарт зөвхөн тоон утга оруулна.
- Огноо төрлийн талбарт он-сар-өдөр форматаар оруулна.
- Текст төрлийн талбарт тоо, үсэг, тэмдэгтээс бүрдсэн мэдээлэл оруулна.
- Ганц сонголт талбарт өгөгдсөн ангилалаас нэгийг сонгоно.
- Заавал бөглөх талбарын өгөгдлийг оруулсан байх.
- Тухайн мэдээлэл дэх код, нэрийг давхцуулахгүйгээр оруулах

## Файлын баганын мэдээлэл

| Баганы нэр | Төрөл | Тайлбар | Заавал бөглөх талбар эсэх |
|---|---|---|---|
| Сургалтын байгууллагын код | Текст | Арга хэмжээний харъяалагдах сургалтын байгууллагын кодыг | Заавал |

| | | | |
|---|---|---|---|
| | | оруулна. Энэ нь Дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд сургалтын байгууллагыг давхцахгүй байдлаар кодолсон код юм. Систем тухайн кодоор сургалтын байгууллагыг танина. Код буруу оруулсан тохиолдолд алдаа заана. Сургалтын байгууллагын кодыг **Систем > Манай байгууллага > Ерөнхий мэдээлэл таб > Үндсэн мэдээлэл хэсэг > Код** талбараас харна уу! | |
| Салбар, бүрэлдэхүүн сургуулийн код | Текст | Арга хэмжээний харъяалагдах салбар, бүрэлдэхүүн сургуулийн кодыг оруулна. Салбар, бүрэлдэхүүн сургуулийн кодыг **Систем > Манай байгууллага >Салбар, бүрэлдэхүүн сургууль > Код** талбараас харна уу! | Нэмэлт |
| Сургалтын нэгжийн код | Текст | Арга хэмжээний харъяалагдах сургалтын нэгжийн кодыг оруулна. Сургалтын нэгжийн кодыг **Систем > Манай байгууллага >Сургалтын нэгж> Код** талбараас харна уу! | Нэмэлт |
| Арга хэмжээний код | Текст | Эрдэм шинжилгээний арга хэмжээний давхцахгүй код бичнэ. | Заавал |
| Арга хэмжээний нэр | Текст | Эрдэм шинжилгээний арга хэмжээний давхцахгүй нэр бичнэ. | Заавал |
| Арга хэмжээний нэр /англи/ | Текст | Эрдэм шинжилгээний арга хэмжээний англи нэр бичнэ. | Заавал |
| Төрөл | Сонголт | Эрдэм шинжилгээний арга хэмжээний төрөл (1. Эрдэм шинжилгээний хурал, 2.Зөвлөгөөн, 3.Үзэсгэлэн, өдөрлөг, 4.Семинар, хэлэлцүүлэг) -ийг сонгоно. | Заавал |
| Хамрах хүрээ | Сонголт | Эрдэм шинжилгээний арга хэмжээний хамрах хүрээний төрөл (1. Олон улсын түвшинд, 2. Үндэсний түвшинд, 3. | Заавал |

| | | | |
|---|---|---|---|
| | | Салбарын түвшинд, 4. Байгууллагын түвшинд, 5. Оюутан багш нарын хүрээнд) -ийг сонгоно. | |
| Эхлэх огноо | Огноо | Арга хэмжээний эхэлсэн огноог оруулна. | Нэмэлт |
| Дуусах огноо | Огноо | Арга хэмжээний дууссан огноог оруулна. | Нэмэлт |
| Зохион байгуулсан газрын төрөл | Сонголт | Арга хэмжээ зохион байгуулсан газрын төрөл (1. Дотоодод, 2. Гадаадад) -ийг сонгоно. | Заавал |
| Цахим эсэх | Сонголт | Аргэ хэмжээ нь цахим эсэхийг сонгоно. | Нэмэлт |
| Оролцогчдын тоо | Тоо | Арга хэмжээнд оролцогчдын тоог оруулна. | Нэмэлт |
| Нэмэлт мэдээлэл | Текст | Дэлгэрэнгүй мэдээллийг оруулна. | Нэмэлт |
| Арга хэмжээний үр дүн (эмхэтгэл, үр дүн) | Текст | Арга хэмжээний эмхэтгэл, үр дүнгийн мэдээлийг оруулна. | Нэмэлт |